

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ	3
1.2. УУЛЫН ХЭСЭГ	4
1.2.1. Уурхайн төлөвлөлт, хүчин чадал	4
1.2.2. Ордын нөөц	4
1.2.3. Овоолгын төлөвлөлт	5
1.2.4. Шимт хөрс хуулалтын төлөвлөлт	5
1.2.5. Технологийн сонголт	6
1.2.6. Техник, тоног төхөөрөмж	6
1.2.7. Усан хангамжийн эх үүсвэр	6
1.2.8. Ус хэрэглээ	6
1.2.9. Хог хаягдал	7
2. ТӨСЛИЙН БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ	8
2.1. Дорноговь аймаг	8
2.2. Хүн ам	8
2.3. Дэд бүтэц	8
2.4. Газар зүй, эдийн засгийн байдал	8
2.5. Амьтны аймаг, ургамал зүй, уур амьсгал	8
2.6. Ордын судлагдсан байдал	10
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	12
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ	13
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
6. ХААЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	23
7. ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ	25
8. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	26
9. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	30
10. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	31
11. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	32
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	34
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	38
14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	40

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Ил уурхайн календарь төлөвлөгөө.....	4
Хүснэгт 2. Нөөцийн нэгдсэн хүснэгт.....	4
Хүснэгт 3. Ашиглалтын жилд уурхайгаас хуулах шимт хөрсний хэмжээ	5
Хүснэгт 4. Ил уурхайн технологи.....	6
Хүснэгт 5. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	12
Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	14
Хүснэгт 7. Уурхайн эвдрэлд өртөх талбай.....	23
Хүснэгт 8. Төслийн хаалт, нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө, зардлын тооцоо.....	24
Хүснэгт 9. Хаалтын дараах мониторингийн зардал	24
Хүснэгт 10. Модны суулгацны үнэ. 1 жилд тарих хэмжээ.....	25
Хүснэгт 11. Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө.....	25
Хүснэгт 12. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	26
Хүснэгт 13. Дүйцүүлэн хамгаалал хийх боломжтой газрууд.....	29
Хүснэгт 14. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	31
Хүснэгт 15. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	32
Хүснэгт 16. БОМТ-ийн биелэлтийг тайлагнах төлөвлөгөө.....	40
Хүснэгт 17. БОМТ-ний нийт зардал	41

ЗУРАГ

Зураг 1. Төслийн талбайн байршил	3
Зураг 2. Талбайн хөрс, ургамал зүйн байдал.....	9
Зураг 3. Дүйцүүлэн хамгаалал хийх боломжтой газар	27

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллага:


Төсөл хэрэгжүүлэгч “Ричмайнинг” ХХК нь 2009 онд Уул уурхай, геологийн тойм судалгаа, зөвлөх үйлчилгээ болон гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар байгуулагдсан /9011202137 улсын бүртгэлийн дугаар бүхий аж ахуй нэгжийн гэрчилгээтэй/ 100% дотоод хөрөнгө оруулалттай компани юм. Монгол улсын ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн MV-022815 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 2347.81 гектар талбайд хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглах зөвшөөрлийг 2054 оны 09р сарын 27-ны өдөр хүртэл авсан байна

Төслийн нэр: “Уулбаян” нүүрсний ордыг ил аргаар ашиглах төсөл

Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл:

Хайгуулын тусгай зөвшөөрөл нь Дорноговь аймгийн Хөвсгөл, Мандах, Мандах сумдын нутагт харьяалагдах бөгөөд Уулбаянгийн чулуун нүүрсний орд нь бүхэлдээ Мандах сумын нутагт оршино. Орд нь Улаанбаатар хотоос 685км, Дорноговь аймгийн төвөөс баруун урд зүгт 221км, Хангийн хилийн боомтоос 160км, Сор говь, Айлбаянгийн ордуудын баруун урд үргэлжлэл дээр хил залган оршдог.

Зүүнбаян Хангийн чиглэлийн төмөр зам ордоос зүүн зүгт 32 км зайтай дайран өнгөрдөг.



Зураг 1. Төслийн талбайн байршил

1.2. УУЛЫН ХЭСЭГ

1.2.1. Уурхайн төлөвлөлт, хүчин чадал

Уулбаян нүүрсний уурхай нь жилд 400.0 мян.тн нүүрс олборлох хүчин чадалтайгаар төлөвлөлөө. Уурхайн ашиглалтын нийт хугацаа 3 жил болно.

Хүснэгт 1. Ил уурхайн календарь төлөвлөгөө

Бүтээгдэхүүн	1 дэх жил	2 дах жил	3 дах жил	Нийт
Хөрс тэсэлгээгүй, м3	2,691,939.0	459,500.0	-	3,151,439.0
Хөрс тэсэрсэн, м3	3,519,498.0	6,128,995.0	7,527,867.0	17,176,360.0
Хөрс, м3	6,211,437.0	6,588,495.0	7,527,867.0	20,327,799.0
Нүүрс, м3	242,424.2	242,424.2	289,212.1	774,060.6
Нүүрс, тн	400,000.0	400,000.0	477,200.0	1,277,200.0
Нийт уулын цул, м3	6,453,861.2	6,830,919.2	7,817,079.1	21,101,859.6
Хөрс хуулалтын коэф, м3/тн	15.5	16.5	15.8	15.9
Нүүрсний ангилал, тн				
1/3 коксжих нүүрс	99,921.1	99,921.1	116,707.8	316,550.0
Дэгдэмхий бодис их хийн нүүрс	149,881.1	149,881.1	175,061.2	474,823.5
Бохирдолтой нүүрс	99,127.2	99,127.2	125,780.6	324,035.0
Эрчим хүчний цэвэр нүүрс	27,755.7	27,755.7	32,418.7	87,930.2
Эрчим хүчний бохирдолтой нүүрс)	23,314.8	23,314.8	27,231.7	73,861.4
НИЙТ НҮҮРС	400,000.0	400,000.0	477,200.0	1,277,200.0

1.2.2. Ордын нөөц

Уулбаянгийн ордын нүүрсний нөөцийг +420м-ийн үнэмлэхүй түвшин хүртэл буюу газрын гадаргаас 400м хүртэл гүнд, жишгийн үзүүлэлтийн шаардлагыг хангаж байгаа нүүрсний давхраасуудын нийт нөөцийг тооцоолон гаргалаа. Нүүрсний нөөцийг тооцоолохдоо 2021-2022 онд өрөмдсөн бүх цооногийн зүсэлт, каротажийн хэмжилтийн тайлал, кернийн дээжийн лабораторийн шинжилгээний үр дүнг бүрэн ашиглалаа. Нүүрсний нөөцийг хэсэг бүрээр, нөөц тооцсон үнэмлэхүй төвшнөөр, нөөцийн зэрэгээр ялган үзүүллээ.

“Ричмайнинг” ХХК хайгуулын ажлыг 2021-2022 онуудад өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж, хайгуулын ажлын үр дүнгийн тайланг 2024 оны 04-р сарын 11-ний өдрийн ЭМБЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн ордын нийт нөөцийг боломжтой (С) зэрэглэлээр цэвэр нүүрсийг 3,433,838.69 тн, чулууны үетэй нүүрсийг 3,474,455.46 тн нүүрсийг Улсын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн.

Хүснэгт 2. Нөөцийн нэгдсэн хүснэгт

Нөөцийн зэрэглэл, нүүрсний төрөл		БАРУУН ХЭСЭГ		ТӨВИЙН ХЭСЭГ		ЗҮҮН ХЭСЭГ		Нийт геологийн нөөц	
		/мян.тн/		/мян.тн/		/мян.тн/		/мян.тн/	
		Нүүрс	Чулууны үетэй нүүрс	Нүүрс	Чулууны үетэй нүүрс	Нүүрс	Чулууны үетэй нүүрс	Нүүрс	Чулууны үетэй нүүрс
С	Исэлдсэн	80.63	81.70					80.63	81.70
	Нүүрс	3,353.20	3,392.76					3353.20	3392.76
Боломжтой (С)		3,433.84	3,474.46					3,433.84	3,474.46

1.2.3. Овоолгын төлөвлөлт

Хөрсний овоолго:

Ордын уул-геологийн нөхцөл, уурхайн хэтийн төлөв, ил уурхайн хүрээний гадна болон гүндээ үлдэж байгаа нөөц, эдийн засгийн үзүүлэлтүүдийг харгалзан үзэж уурхайд авто тээвэртэй, хөрсний гадаад овоолготой ашиглалтын системийг сонгон авсан.

Ашиглалтын нийт хугацаанд уурхайн хөрсний 0.22%-ийг шимт болон шимэрхэг хөрсний хэмжээ эзэлж байгаа бөгөөд үлдэгдэл 99.78%-ийг үндсэн хөрс эзэлж байна. Уурхайгаас гарах нийт хөрсийг утгуурт ачигч, экскаватораар ухаж ачин, автотээврээр тээвэрлэж шимт болон үндсэн хөрсний гадаад овоолгод байршуулах бөгөөд овоолгын хажуугийн тогтворжилтын өнцөг нь чулуулгийн физик-механикийн шинж чанараас хамааран 36-47° байна. Овоолго нь бульдозерын захлах хэлбэрийн гадаад овоолго байна.

Хөрсний овоолгын талбайн сонголтыг захиалагч байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр ордын хайгуулын ажлын үед өрөмдөгдсөн цооногуудаар нүүрсний үр ашигтай нөөцийн давхраас байхгүй гэдэг нь нотлогдсон талбайг сонгосон бөгөөд тээврийн зайг ашиглалтын жил тус бүрдээ жигд тогтмол байх, мөн уурхайн бүх нөөцийг олборлох үеийн ил уурхайн эцсийн хүрээ, түүний нурлын бүсийн гадна байрлахаар тооцоолсон болно.

Нүүрсний овоолго:

Уурхайгаас олборлосон нүүрсийг нүүрсний түр хадгалах талбайд хурааж, түүнээсээ ахин борлуулалтын гадаад тээвэрт ачилт хийнэ. Нүүрс ачилтыг XCMG фирмийн 3м³ утгуурын багтаамжтай ZN50GN дугуйт ачигчаар ачина.

Уурхайн 300,000-400,000 тн нүүрс агуулах хүчин чадал бүхий нүүрс хадгалах талбай байгуулна.

1.2.4. Шимт хөрс хуулалтын төлөвлөлт

Ордын ашиглалтын явцад уурхайн үйл ажиллагаанд өртөх уурхайн олборлолтын талбай овоолгын доод хэсэг, барилга байгууламж, замын өнгөн хэсгийн шимт хөрсийг уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө Монгол улсад дагаж мөрддөг шаардлага стандартын дагуу элс элсэнцэр зэрэг ургамал ургах боломжтой шимэрхэг хөрсийг 0.1 м хүртэл зузаантайгаар урьдчилан хуулна.

Шимт хөрс хуулах ажилд бульдозер ашиглах бөгөөд бульдозерын хуулсан хөрсийг утгуурт ачигчаар ачиж автосамосвалаар тээвэрлэн уурхайн хөрсний овоолгын ард байрлах шимт хөрсний овоолгод байршуулна. Ингэж хуулж бэлтгэсэн шимт хөрс нь орд ашиглалтын явцад болон ордыг ашиглаж дууссаны дараах нөхөн сэргээлтийн ажилд ашиглагдах юм.

Шимт хөрсний овоолгын өндөр нь 4 м байх бөгөөд хажуугийн өнцөг нь 25-30 градус байна. Уурхайн ашиглалтын хугацаанд нийт 430,258.0 мян.м³ шимт хөрс хуулна.

Хүснэгт 3. Ашиглалтын жилд уурхайгаас хуулах шимт хөрсний хэмжээ

Байршил	Эвдэгдэх газрын хэмжээ, м2	Шимт хөрс хуулах зузаан,м	Хуулах шимт хөрсний хэмжээ
Уурхай-1	223,887.00	0.3	67,166.10
Уурхай-2	91,835.00	0.3	27,550.50
Хөрсний овоолго	628,508.50	0.3	188,552.55
Нүүрсний агуулах	148,926.90	0.3	44,678.07
Уурхайн тосгон	22,500.00	0.3	6,750.00
Зам талбай	271,785.93	0.3	81,535.78
ШТС	9,750.00	0.3	2,925.00

Байршил	Эвдэгдэх газрын хэмжээ, м ²	Шимт хөрс хуулах зузаан,м	Хуулах шимт хөрсний хэмжээ
Засварын талбай	37,000.00	0.3	11,100.00
Нийт	1,434,193.33	0.3	430,258.00

1.2.5. Технологийн сонголт

Төслийн ТЭЗҮ-д Уулбаян ордын уул техникийн нөхцөлд үндэслэн тээвэртэй ашиглалтын систем хэрэглэх боломжтой гэж үзэн гадаад болон дотоод овоолготой тээвэртэй ашиглалтын системийг сонгосон байна.

Хүснэгт 4. Ил уурхайн технологи

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Тээвэртэй ашиглалтын технологи	Хөрс хуулалт	• Шимт хөрс хуулалт
		• Өрөмдлөг тэсэлгээ
		• Ухаж ачих
		• Тээвэрлэх
		• Овоолох
	Олборлолт	• Ухаж ачих
		• Тээвэрлэх
		• Овоолох

1.2.6. Техник, тоног төхөөрөмж

Ил уурхайн ашиглалтын системийн технологийн үе шатуудад 21 төрлийн техник, тоног төхөөрөмжүүдийг ашиглана.

1.2.7. Усан хангамжийн эх үүсвэр

Уурхайн усны хэрэглээг хангах зорилгоор тусгай зөвшөөрлийн талбайн урд шинээр худаг гаргана.

Мөн тусгай зөвшөөрлийн талбайн зэргэлдээ орших “Сорговь” нүүрсний уурхайн 2013 онд усан хангамжийн эх үүсвэрийн ундаргыг тогтоох зорилгоор “Эрдэнэ Дриллинг” ХХК-аар талбайн зүүн урагш ил уурхайгаас 8 км-ийн зайд гидрогеологийн усны хайгуулын ажлыг хийлгэсэн байна. Энэхүү цооногоос ахуйн болон тоос дарах зорилгоор ус ашиглаж байгаа бөгөөд шаардлагатай тохиолдолд харилцан тохиролцон тус худгаас усны хэрэглээг хэрэглэж болно.

1.2.8. Ус хэрэглээ

Ил уурхайн ашиглалтын үеийн усны хэрэглээ нь унд-ахуйн ба технологийн ус хэрэглээ гэсэн 2 хэсэгт хуваагдана.

Нийт ус хэрэглээ

Ил уурхайн ашиглалтын үеийн нийт ус хэрэглээ нь: $Q=Q_1+Q_2+Q_3=30,0+142,4+48,0=220,4$ м³/хон=9,18 м³/цаг=2,55 л/с

Үүнд:

Q – Нийт ус хэрэглээ м³/хон

Q₁ – Унд ахуйн ус хэрэглээ - м³/хон Q₂ – Зам талбайн усалгаа - м³/хон

Q₃ – Ногоон байгууламжийн усалгаа - м³/хон

Уурхайн усны хэрэглээг хангах зориулалтаар гаргасан гүний худгийн ундрага нь 5,0 л/с байгаа нь усны хэрэглээг хангаж байна.

1.2.9. Хог хаягдал

Уурхайн үйл ажиллагааны үед ахуйн гаралтай хатуу, шингэн хаягдлаас гадна техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний хаягдал гарна.

- Ахуйн хатуу хог хаягдал: Төслийн үйл ажиллагааны үед ажилчдын ахуйн хэрэглээнээс хоногт дунджаар 300 кг орчим хатуу хог хаягдал үүсэх бөгөөд уг хаягдлыг төслийн талбайд байрлах хогийн саванд дахин боловсруулах боломжтой болон боломжгүйгээр нь ангилан ялгаж, дахин боловсруулах боломжтой хаягдлыг (Шил, лааз, хуванцар, цаас, гялгар уут г.м) хоёрдогч түүхий эдийн цэгт нийлүүлж, дахин боловсруулах боломжгүй хаягдлыг ойролцоох зөвшөөрөгдсөн хог хаягдлын цэгт хаях буюу уурхайн ухалга овоолгод булшилж болно.
- Ахуйн шингэн хаягдал: Төслийн үйл ажиллагааны үед ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах шингэн хаягдал нь ажилчдын тооноос хамаараад хоногт 21,0 м³ орчим шингэн хаягдал гарахаар байна. Ахуйн бохир усыг төвлөрсөн шугам сүлжээгээр дамжуулан бага оврын цэвэрлэх байгууламжаар цэвэрлэн байгальд хаях буюу дахин ашиглах саарал ус болгох боломжтой юм
- Засвар үйлчилгээний хаягдал: Машин механизмын засвар үйлчилгээний үед моторын тос, тосоор бохирдсон материал, ашигласан аккумулятор, дугуй, төмөр эд ангийн хаягдал гэх мэт хог хаягдал гарна. Эдгээрийг мөн дахин ашиглах боломжтой боломжгүйгээр нь ялган ангилна.
- Хийн хаягдал: Төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор 2 төрлийн эх үүсвэрээс хий хаягдал үүсч нутаг дэвсгэрээр тархалт явагдана.

2. ТӨСЛИЙН БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1. Дорноговь аймаг

Дорноговь аймаг нь манай орны урд хэсэгт Галба–Өөш–Долоодын говийн сав газарт оршдог. Дорноговь аймаг нь 109.5 мянган км.кв нутаг дэвсгэртэй 14 сум, 60 багтай. Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар гэх 5 аймагтай хөрш оршдог. Урд талаараа БНХАУ-тай 600 км-ээр хиллэдэг. Дорноговь аймгийн төв Сайншанд сум нь 234.2 мянган га нутаг дэвсгэртэй.

2.2. Хүн ам

Дорноговь аймаг нь 69.6 мянган хүн амтай 21.7 мянган айл өрхтэй. Хүн амын 50.5 хувь нь эрэгтэй, 49.5 хувь нь эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны

38.6 мянган хүн байна.

2.3. Дэд бүтэц

Тус аймагт 4 чиглэлийн 531 км урт төмөр зам, 722 км урт хатуу хучилттай авто зам, олон улсын агаарын тээвэр дайран өнгөрөх гурван нисэх буудалтай. Мөн Багануур - Сайншандыг холбосон 220 кВ, Сайншанд - Замын-Үүдийг холбосон 110 кВ, Сайншанд — Зүүнбаянг холбосон 35 кВ-ийн цахилгаан дамжуулах агаарын шугамтай.

АШУҮИС-ийн салбар сургууль, МСҮТ, Төмөр замын МСҮТ, ЕБ-ын 20 сургууль, 21 цэцэрлэг, эрүүл мэндийн 72 байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна. Аж ахуй нэгжийн хувьд 6.2 хувь нь төрийн байгууллага, 93.8 хувь нь хувийн байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна.

Хилийн байнгын үйл ажиллагаатай Замын-Үүд болон Ханги-Мандалын боомтуудтай.

2.4. Газар зүй, эдийн засгийн байдал

Далайн түвшнээс дээш дунджаар 900-1400 м өргөгдсөн. Нийт газар нутаг нь экосистемийн хувьд хээржүү цөлийн бүсэд багтдаг. Мандах суманд байгалийн сонин тогтоцтой археологийн олдвор ихтэй газар олон бөгөөд Борзонгийн говь, Зээмгэний говь, Хармагтайн говь, Эргэлийн зоо зэрэг улсын тусгай хамгаалалттай газрууд бий.

Мөн Мандах сумын нийт ажилчдын 60 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 22.6 хувь нь үйлдвэрлэлийн салбарт, үлдсэн 17.4 хувь нь үйлчилгээний салбарт ажиллаж байна.

Дорноговь аймагт газрын тос, зэс молибден, жонш, нүүрс, уран, шохойн чулуу зэрэг ордын илэрц ихтэй бөгөөд нефть, нүүрс, зэс, төмрийн боловсруулах, баяжуулах үйлдвэрүүд байдаг. Сүүлийн байдлаар тоологдсон малын тоо 2,147.2 мянгад хүрээд байна.

Дорноговь аймагт Хутаг уул, Оцол, Сансар, Их Багадулаан, Аргалант, Хан Баянзүрх хайрхан зэрэг уулс бий. Халзан уул, Бүсийн Чулуу, Толь зэрэг рашаантай бөгөөд газрын доорх усны нөөц ихтэй. Нутгийн ихэнх хэсэгт говийн бор хөрс болон элс байдаг.

2.5. Амьтны аймаг, ургамал зүй, уур амьсгал

Ургамал зүй: Аймаг бүхэлдээ хээржүү цөлийн бүсэд багтдаг буюу говь хээр хосолсон нутагтай. Хөрсний хувьд говийн хөрсний их мужийн говийн бор хөрсний бүслүүрт хамаарах ба сайр чулуу, элс шавранцар, хурдас дээр тогтсон байдаг.



Зураг 2. Талбайн хөрс, ургамал зүйн байдал

Ургамлын бүрхэвчийг бүрдүүлэгч гол нэр төрлийн өвс ургамал нь шивээ, хялгана, хазаар, агь, таана, хөмүүл, зангуу, божмог, шарилж зэрэг болно. Дов толгодын гуу жалга, хажуу бэл, нам дор газраар алтан харгана, хар харгана, дэрс, буйлс ургадаг. Нутаг дэвсгэрийн хэмжээнд модлог ургамал байхгүй, нуур булгийн эрэг орчмоор ургамлын бүрхэвч нь арай шигүү байна.

Мандах сумын нутаг дэвсгэр нь уул, гүвээ толгод бүхий заримдаг цөлийн бор саарал, цайвар бор, хужир мараат хөрстэй, хялгана, харганат цөлийн хээр алаг өвст ургамалтай, байгалийн хээржүү цөлд хамаарна. Бударгана, шар мод, гашуун суль, агь, хөмөл, таана, ерхөг, тэсэг, гоёо, цулхир, хармаг, алтан харгана, хайлаас зэрэг ургамлууд ургадаг.

Амьтны аймаг: Амьтны аймгийн хувьд ургамлын бүрхэвч сийрэг боловч амьтны аймгийн тархалт тоо хэмжээний хувьд нэлээд их юм. Туурайтнаас хамгийн их тархсан нь цагаан зээр юм. Түүнчлэн жигүүртнээс тас, бүргэд, сар, элээ, хэрээ, харцага, ногтруу, өвөөлж, тоодог, хэвлээр явагчдаас могой, гүрвэл, мэрэгчдээс сохор номин, шар сүүлт, бозлог, алаг даага, тарвага, махчин амьтдаас үнэг, хярс, өмхий хүрэн, бага хэмжээгээр чоно, шавж идэштнээс зараа зэрэг амьтад тохиолдоно.

Түүнээс гадна нүүдлийн шувууд хавар намарт цөөнгүй байдаг. Байгалийн тэнцвэрт байдлыг хангах, ховордсон амьтан ургамлыг хамгаалах зорилгоор говийн ихэнх амьтдыг агнах, заг зэрэг ургамлыг устгахыг хориглосон байдаг.

Уур амьсгал: Уур амьсгалын хувьд дулаан зунтай чийг дутмаг мужид багтана. Бүх нутгаар агаарын хэм харьцангуй жигд байдаг. Ургамалшил тачирхан, чулуурхаг буюу элсэрхэг гадаргатай тул наранд халж агаарын хэмийг нэлээд дээшлүүлдэг. Хамгийн их хүйтрэлт 1-р сард, хамгийн их халуун 7-р сард болдог. Өвөл 20–15° хааяа 36-40° хүрч хүйтэрнэ.

Дулааны улиралд 20 — 25° халах боловч 30° ба түүнээс дээш хэм халах явдал жилд дунджаар 30-39 хоног тохиолдоно. Чийгшилт дунджаар 45-50% байдаг. Ус чийг багатай тул манан бараг ажиглагдахгүй. Хур тунадасны хэмжээ маш ядмаг юм. Энэ нь хойд мөсөн далайн болон номхон далайн агаар нэвтрэн ирэх боломж муу байдаг, гол төлөв эх газрын эрс тэс уур амьсгалтай байдалтай холбоотой юм. Хур тунадас жилд 30 орчим хоног бороо орж 100 мм орчим тунадас унах

Цас маш бага орж цасан бүрхүүл бараг тогтдоггүй, 1–2 см хамгийн их нь 14 см хүрдэг бөгөөд 120–130 хоног цоохор цас тогтдогийг тогтоожээ. Хоногийн хэмийн хэлбэлзэл их, салхийг хаах өндөр уул нуруу байхгүй тул салхины хоногийн хэлбэлзэл ихтэй байдаг. Жилийн дунджаар авч үзвэл

салхигүй өдрийн тоо 1320 хоног байдаг. Хамгийн их салхи хавар тохиолдох бөгөөд 5.9 м/сек, хамгийн бага салхилалт өвөл буюу 4.2–4.3 м/сек-ийн дундаж хурдтай байдаг.

Жилийн салхины дундаж хурд 4.0 м/сек бөгөөд жилд дунджаар 32–38 хоног 15 м/сек хүртэл хүчтэй цасан ба шороон шуурга шуурна. Хүчтэй салхилах хугацаа 4-6 хүртэл хоног үргэлжлэх үе байдаг. Хамгийн тохиромж муутай улирал нь хавар юм. Намар удаан үргэлжилнэ. Өвөл салхи багатай дулаахан болдог. Харин зун ялангуяа 7-р сард их халдаг онцлогтой.

2.6. Ордын судлагдсан байдал

Судалгааны талбай нь региональ структурын байрлалын хувьд эртний картонали бүсийн хэмжээнд хөгжсөн Хутаг уулын террейний (Б.Бадарч) төв хэсэгт хамаарагддаг. Ерөнхийдөө баруун урагш болон зүүн хойш сунасан Нүхт давааны томоохон региональ хагаралаар зааглагдсан бүс үүсгэдэг. Хайгуулын талбай орчимд доорх хурдас чулуулаг тархжээ. Үүнд:

- Палеопротерозой. Хутаг уул формац /PPhu/;
- Мезопротерозой эктази-стени. Норовзээг формац. (PR₂₋₃ pz)
- Доод-дунд карбон. Мөргөцөг формац (C₁₋₂mr):
- Доод-дунд пермь. Харнүдэн формац (P₁₋₂hn):
- Доод-дунд юра. Хамархөөвөр формац. (J₁₋₂ hh):
- Хожуу юра. Шарил формац (J₃sr):
- Дээд цэрд. Баруунгоёот формац (K₁bg):
- Дээд цэрд. Баянширээгийн формац (K₁ bs):
- Доод цэрд. Хөхтээг формац. (K₁ht):
- Доод цэрд. Цагаанцав формац (K₁ cc₁):
- Плейстоцен: (Q₁):
- Голоцен: (Q₂):

Маршрутын судалгаа. Энэ үед XIX зууны сүүлч XX зууны эхэн үе хамаарна. Энэ үед Германы эрдэмтэн Ф.Рихтгофен (1860-70), Оросын жуулчин С.М.Прежевальский (1851), М.В.Певцов (1878-79), Г.Н.Потанин, В.А.Обручев (1892-93), Английн эрдэмтэн Ю.Мильн (1877), АНУ-ын геологич Ч.Беркли, П.Моррис, Ю.Эндрюс (1922-23), Оросын эрдэмтэн З.А.Лебедева (1932) нар ихээхэн хувь нэмэр оруулсан байна.

Талбайн судалгаа. 1940 онд 1:500000-ны масштабтай геологийн зураглалын ажлыг Зөвлөлтийн “Спецгео” геологи-хайгуулын экспедицийн 17-р анги Ю.С.Желубовскийн удирдлагаар гүйцэтгэж нефть, битумын илрэл олж тогтоосон байдаг. Энэ үеэс эхлэн Дорноговь аймгийн мезозойн хурдас тархсан томоохон депрессүүдэд нефтийг эрж хайх, эрлийн ажлын эхлэл нь тавигджээ.

1941 онд В.В.Дельнов нар судалгааны талбайн хойд хэсэг дэх Зүүнбаянгийн дүүрэгт 1:50000-ны масштабтай геологийн зураглалын ажил гүйцэтгэсэн байна. Энэ хэсэгт нь Дорнодын геологийн экспедицийн 18-р ангийн геологичид болох С.Н.Алексейчик нар нефть, битумын эрэл-хайгуулын ажил хийж нефтийн чанарыг тодорхойлж анхны нөөцийг тогтоожээ.

1946 оноос И.Е.Ефремовын удирдсан Зөвлөлтийн ШУА-ийн палеонтологийн экспедицийн Хар хөтөл уул, Эргэлийн зоо, Сайншанд хотын орчимд ажиллаж, амьтны үлдвэр цуглуулж формацуудыг шинээр нээсэн нь Төв Азийн палеозоографийн хувьд үнэтэй хувь нэмэр болжээ.

Амьтан ургамлын үлдвэрээр юрийн дээд нэгтгэлийн Шарил, доод цэрдийн Цагаанцав формац, доод цэрдийн Зүүнбаян формацийн доод дэд, дээд дэд формац, дээд цэрдийн

Сайншанд, Баянширээ формацуудыг тус нутгийн хэмжээнд ангилжээ. Өмнөд Монголын карбон, пермийн цаг үеийн хурдас хуримтлалыг С.Н.Алексейчик, А.Я.Стефаненко нар 1947 онд, нүүрсний ордын талаар Ф.К.Шипулин 1954 онд нэгтгэж гаргасан нь нийтийн хүртээл болжээ.

Б.И.Васильев, А.А.Архипова нар 1966-1967 онд Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгуудын нутагт 1:500000-ны масштабтай геологи-гидрогеологийн ажил явуулж судалгааны талбайн баруун хойд хэсэгт Цагаан суваргын хүдрийн дүүрэгт доод карбоны Сайншанд худаг, Гүнбаян, Дөшийн овоо, пермийн Аргалант формацыг ялган Цагаан цавын гөлтгөнийн орд, зэсийн илрэл, эрдэсжсэн цэг нээн олжээ. Бүтэц хэлбэршлийн бүдүүвчид Өндөр шил, Бор хайрхан, Цагаан цавын бүс ялгаж, дунд төрмөлийн гүвдэл, хотгор зэрэг бүтцүүд ялгасан байна.

Д.Дашцэрэн, С.Жагар нар Дорноговь аймгийн Мандах, Мандах, Хөвсгөл сумдын нутагт 1:500000-ны масштабтай нүүрсний эрэл-шалгалтын ажил гүйцэтгэж, анх төрмөл, силур, девон, чулуун нүүрс, пермь, юра, цэрд, палеоген, дөрөвдөгчийн хурдас тархсаныг тогтоож, хожуу анх төрмөл, дунд-хожуу девон, пермь, хожуу триас-түрүү юрийн гүний цогцолбор ангилжээ.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй үзүүлэлтүүдийг сонгон авсанаас хөрсний микроорганизм, амьтадын тархац нутаг, агаар орчинд тоос үүсгэх, хөрсний бохирдол, элэгдэл эвдрэл, ойр орчинд дуу чимээ ихсэх, газар ашиглалт, бэлчээр хомсдуулах, байгалийн түүхий эдийн нөөц багасах, үер ус орж голын сайр гольдрил өөрчлөгдөх, уурхайн үйл ажиллагаатай холбоотой осол аваарь гарах, байгалийн төрх байдал ландшафт өөрчлөгдөх зэрэг сөрөг нөлөөллүүд их, дунд, бага зэргийн эрчимтэйгээр нөлөөлж болзошгүй байна.

Харин байгалийн түүхий эрдэс баялагийг бүтээн байгуулалтын ажилд ашиглахад бэлэн болгох, нутгийн иргэдэд ажлын байр шинээр бий болгох зэргээр нийгэмд эерэг нөлөө үзүүлж болохоор байна.

Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүд

Хүснэгт 5. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Биосферийн элементүүд	Уулын үйлдвэрлэлийн үзүүлэх сөрөг нөлөөлөл	Гарч болзошгүй үр дагавар
Хөрс	Хөрс хуулалт Технологийн болон гадаад тээврийн зам хийх	• Газрын гадаргуугийн деформаци • Хөрсний элэгдэл, эвдрэлд орох • Газрын унаган төрх өөрчлөгдөх
Ус	Уурхайн усны хэрэглээг хянах Ил задгай талбайд ус тогтох	• Газрын доорх усны багасалт • Хөрсөнд ШТМ алдсанаас гүний усанд нөлөөлөх • Шатах тослох материалаар бохирдох
Агаар	Технологийн болон гадаад тээврийн зам	• Тоосжилт, • Агаарын бохирдол
Ургамал	Ургамлын бүрхэвч тоосжилтод дарагдах Уурхайн ухалтад	• Ургамлан нөмрөг устгах, • Ургамлын төрөл зүйл хомсдох - Бэлчээрийн талбай багасах
Амьтан		• Амьтдын амьдрах орон зай нь хумигдах • Байршил тархалт өөрчлөгдөх • Мал амьтан ашиглалтын талбай руу орох, карьерт унах

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Дорноговь аймгийн Мандах сумын нутаг дэвсгэрт “Ричмайнинг” ХХК-ийн хэрэгжүүлэх “Уулбаян” нэртэй нүүрсний ордыг ил аргаар олборлох төслийн үнэлгээний ажлын явцад үйл ажиллагааны товч танилцуулга, эрхлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны тодорхойлолт болон төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн суурь төлөв байдлыг тодруулж үйл ажиллагааны явцад байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх гол сөрөг нөлөөллүүд тэдгээрийн цар хүрээг тооцон сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, багасгах арга хэмжээний зөвлөмжийн хүрээнд энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) боловсрууллаа.

Төслийн хэрэгжилтийн явцад барилга байгууламжийн бүтээн байгуулалт, уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас хамгийн ихээр эвдрэлд орж сөрөг нөлөөлөлд өртөх бүрэлдэхүүн нь хөрсөн бүрхэвч юм.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уулбаян төсөл хэрэгжүүлэхэд барилга бүтээн байгуулалтын үе шат болон ил уурхайн олборлолтын үйл ажиллагааны үе шатанд гарч болох гол сөрөг нөлөөллүүдийг урьдчилсан байдлаар тодорхойлсны хүрээнд Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөг урьдчилсан байдлаар боловсрууллаа.

Уурхайн үйл ажиллагааны бүхий л үе шатанд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг тэргүүлэх чиглэл болгон авч үзэж хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх зарчмыг баримтлан ажиллах бөгөөд дараах арга хэмжээнүүдийг авч ажиллана. Үүнд:

1. Монгол улсын холбогдох хууль тогтоомж стандартууд болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хариуцлагатай, байгаль орчинд ээлтэй туршлагуудыг хэрэгжүүлж ажиллах
2. Нийтээр дагаж мөрдөх байгаль орчны бодлого, хууль, тогтоомжид нийцүүлэн төслийн бүх үйл ажиллагааг явуулна.
3. Уулбаян төслийн Байгаль орчны удирдлагын тогтолцоо нь тус уурхайн бизнес төлөвлөгөөний салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тасралтгүй хэрэгжүүлж ажиллана.

5.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон компанийн дотоод бичиг баримт болох Агаар мандалд ялгарах бохирдлын удирдлагын төлөвлөгөөнд агаарын чанарт нөлөөлөх үйл ажиллагаануудыг тодорхойлсон байдаг. Тухайлбал: хүнд машин механизм, бүх төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, ил уурхай, тэсэлгээ, уурын зуухын түлшний хэрэглээ зэргээс агаарын чанарт нөлөөлөх сөрөг нөлөөллүүд бий болох эрсдэлтэй. Эдгээр эх үүсвэрүүдээс хүрээлэн буй орчны агаарын чанарт нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж						Баримтлах стандарт, аргачлал
			2025	2026	2027	2028	2029	давтамж	
Агаарын чанар									
Олборлолтын явцад карьерын ханыг ухах нураах, ачих, тээвэрлэх, овоолгод байршуулах зэрэг	10 м/с-ээс дээш хүчтэй салхитай үед олборлолтын үйл ажиллагааг түр зогсоох	-	-	-	-	-	-	Салхины хүч ихээр нэмэгддэг үеүдэд	MNS3113:1981 “Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага”

“Уулбаян” нүүрсний ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

үйл ажиллагаанаас тоосжилт үүсэж агаарын чанарт нөлөөлөх	Уурхайн дотоод, гадаад тээврийн замыг шаардлагатай үед чийгшүүлж усалгаа хийх, тоос дарагч бодис ашиглах	15.4	3.0	3.0	3.0	3.2	3.2	Хуурайш илттай үеүдэд	MNS3384:1982 “Агаар мандал-Агаарын дээжлэлт шинжилгээ”
	Нүүрс түр хадгалах нүүрсний агуулахын, нүүрсний овоолгод хаалт хийх, хаалтны бүрэн бүтэн байдлыг хангах	9.5	3.0	3.0	3.5	-	-	Үйл ажиллаг ааны туршид	MNS ISO4227-2002 “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө”
Шатах тослох Материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас ууршимтгай органик нэгдлүүд агаарт дэгдэж тухайн орчны агаар болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг яаралтай авах, саармагжуулах хэрэгслийг талбайд бэлэн байлгах	10.5	3.5	2.0	2.0	1.5	1.0	Үйл ажиллаг ааны туршид	MNS4585-2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS5885-2008 “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага” MNS6063-2010 “Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны

Бүтээгдэхүүнийг тээвэрлэх үед хүнд даацын машин механикийн хөдөлгөөнөөр сул шороо үүсэж, тоосжилт ихсэж агаарын чанарт нөлөөлөх	Тээвэрлэлтийн үед хурдны хязгаар тогтоох (40 км/цагаас хэтрэхгүй байх), тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, цаашид засаж сайжруулах	3.2	1.0	1.2	1.2	-	-	Үйл ажиллаг ааны туршид	агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ” MNS4990-2000 “ХААЭА. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага”.
	Уурхайгаас дотоод гадаад тээврийн гол замын сүлжээ, маршрутыг тогтоох	3.0	1.0	1.0	1.0	-	-		
Машин техник, тоног төхөөрөмжийн хөдөлгүүрийн яндангаас гарах утаа, тортог бусад элемент зэрэг нь агаарын чанарт нөлөөлөх	Тээврийн хэрэгслүүдэд Монгол Улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын стандартууд (MNS 5013:2003 бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид, MNS 5014:2003 дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид) болон Олон улсын холбогдох стандартуудын шаардлагын дагуу хяналт хийж, түүнд нийцүүлэх	Үйл ажиллаг ааны зардалд тусгах	-	-	-	-	-	Үйл ажиллаг ааны туршид	
	Ашиглагдаж буй машин техникээс ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, техникийн үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Үйл ажиллаг ааны зардалд тусгах	-	-	-	-	-	Үйл ажиллаг ааны туршид	

Газрын гадарга, хөрсөн бүрхэвч										
